



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 26

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, "Номын сангийн ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг худалдах, солилцох, данснаас хасах журам"-ын 3.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 2.2, 2.4, 8.г дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. С.Буяннэмэхийн нэрэмжит Дундговь аймгийн төв номын сангийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13287 ширхэг 4,964,460.5 /Дөрвөн сая есөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун жаран төгрөг тавин мөнгө/-ний ном, 21 нэр төрлийн 242 ширхэг 7,053,927.9 /Долоон сая тавин гурван мянга есөн зуун хорин долоон төгрөг ерэн мөнгө/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн эд хөрөнгийг хавсралтын дагуу акталж устгахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл, Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор зохион байгуулж актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг С.Буяннэмэхийн нэрэмжит Дундговь аймгийн төв номын сан /Ц.Одончимэг/-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭГЧ  Б.ДОРЖСҮМБЭР



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
11. сарын 29 өдрийн 26 тоот тогтоолын хавсралт

Акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

№	Үндсэн хөрөнгийн нэр	Нэгж	Өртөг үнэ	Ашиглалтанд орсон	Элэгдэл	Тоо ширхэг	Нийт өртөг
1	Ширээ 1	ш	42,735.00	08.11.25	42,735.00	1	42,735
2	Өлгүүр	ш	36,630.00	08.12.25	146,520.00	4	146,520
3	Уншигчийн өлгүүр	ш	12,210.00	08.12.25	36,630.00	6	73,260
4	Агаар чийгшүүлэгч	ш	60,000.00	15.09.03	120,000.00	2	120,000
5	Өнгөт телевизор	ш	271,350.00	00.01.01	271,350.00	1	271,350
6	Чех дэвсгэр	метр	4,341.60	86.01.01	95,515.20	22	95,515.2
7	Чех дэвсгэр	метр	8,683.20	86.01.01	52,099.20	6	52,099.2
8	Чех дэвсгэр 1	метр	4,341.60	86.01.01	156,297.60	36	156,297.6
9	Чех дэвсгэр 2	метр	4,341.60	86.01.01	625,190.40	144	625,190.4
10	Өнгөт принтер	ш	565,313.00	02.01.01	565,312.50	1	565,312.5
11	Телефон аппарат	ш	14,652.00	01.01.01	14,652.00	1	14,652
12	Компьютер р-4	ш	384,450.00	06.12.25	1,537,800.00	4	1,537,800
13	UPS	ш	85,347.90	06.12.25	85,347.90	1	85,347.9
14	DVD комбо	ш	78,235.60	06.01.01	78,235.57	1	78,235.57
15	Бар код уншигч	ш	230,835.00	09.06.01	230,835.00	1	230,835
16	Компьютер 1	ш	1,542,173.00	02.01.01	1,542,172.51	1	1,542,172.5
17	Бичгийн ширээ	ш	97,680.00	07.11.24	195,360.00	2	195,360
18	Дижетал аппарат	ш	189,255.00	07.11.24	189,255.00	1	189,255
19	Проектор	ш	800,000.00	10.12.25	800,000.00	1	800,000
20	Номын тавиур	ш	67,155.00	07.11.24	134,310.00	1	67,155
21	Сандал ширээ / хүрэн. ногоон эрэн/	ш	32,967.00	07.11.24	164,835.00	5	164,835
22	Ном	ш				13,278	4,964,460.5
НИЙТ						13,529	12,018,388.4